



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/19/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК  
Гүйцэтгэх захирал С.Энхтөр  
Утас: 95957791  
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо  
Утас: 90098901  
Цахим хаяг: соо@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	412
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Зөвлөмж .....	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ШША	Шүүхийн шинжилгээний алба
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sulfbaatar@audit.gov.mn

2023.02.24 № 508

талай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

СҮХБААТАР АЙМГИЙН УС, ЦАГ УУР  
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
ДАРГА Х.ЭНХБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

### Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээнд 862,1 сая төгрөгийн урсгал зардал төлөвлөж, гүйцэтгэлээр 98.9 хувьтай хэрэгжсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангаас нэмэлт санхүүжилт 25,4 сая төгрөгийг олгож, зарцуулсныг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>38,351,094.86</b>	<b>45,110,150.11</b>
35	БАРАА МАТЕРИАЛ	38,351,094.86	45,110,150.11
351	Түүхий эд материал	25,766,011.87	30,916,067.12
35110	Тусгай зориулалттай материал	25,766,011.87	30,916,067.12
354	Хангамжийн материал	12,189,082.99	12,889,082.99
35410	Бичиг хэргийн материал	409,740.00	409,740.00
35420	Аж ахуйн материал	5,174,666.67	5,874,666.67
35430	Сэлбэг хэрэгсэл	6,604,676.32	6,604,676.32
35600	Мал амьтад	396,000.00	1,305,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>401,730,085.63</b>	<b>414,664,933.41</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	401,730,085.63	414,664,933.41
392	Биет хөрөнгө	354,073,725.63	367,216,026.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	152,722,061.66	170,222,061.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,739,832.64)	(63,857,075.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	437,407,573.78	437,407,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(393,270,893.40)	(403,132,822.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	275,645,600.68	341,474,168.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(82,571,610.96)	(129,908,074.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,931,858.00	8,931,858.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,800,748.30)	(6,819,358.58)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,498,868.97	18,952,868.97
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,749,152.16)	(6,055,173.13)
393	Биет бус хөрөнгө	47,656,360.00	47,448,906.64
39301	Програм хангамж	732,360.00	732,360.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(207,453.36)
39303	Бусад биет бус хөрөнгө	46,924,000.00	46,924,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>440,081,180.49</b>	<b>459,775,083.52</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>440,081,180.49</b>	<b>459,775,083.52</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	440,081,180.49	459,775,083.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	627,273,463.60	627,273,463.60
51101	Өмч: - төрийн	627,273,463.60	627,273,463.60
512	Хуримтлагдсан үр дүн	(231,088,068.69)	(211,394,165.66)
51210	Өмнөх үеийн үр дүн	(231,088,068.69)	(231,088,068.69)
51220	Тайлант үеийн үр дүн	-	19,693,903.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,895,785.58	43,895,785.58
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>440,081,180.49</b>	<b>459,775,083.52</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>938,630,816.49</b>	<b>991,483,469.50</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>97,757,197.99</b>	<b>104,068,033.50</b>
120	Нийтлэг татварын бус орлого	97,757,197.99	104,068,033.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	76,474,856.04	104,068,033.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	76,374,856.04	103,968,033.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	21,282,341.95	
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>840,873,618.50</b>	<b>887,415,436.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>823,662,000.00</b>	<b>861,986,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	823,662,000.00	861,986,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,211,618.50	25,428,536.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,524,600.00	18,498,650.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,089,706.00	6,679,886.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	597,312.50	250,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>911,877,164.68</b>	<b>971,789,566.47</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>911,877,164.68</b>	<b>971,789,566.47</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>886,325,048.85</b>	<b>962,265,037.06</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	682,221,032.59	731,338,323.96
210101	Үндсэн цалин	462,273,737.82	522,287,115.04
210102	Нэмэгдэл	196,090,465.63	161,226,592.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,856,829.14	31,940,367.35
210104	Урамшуулал	00.00	15,884,249.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,196,280.58	92,158,106.63
210201	Тэтгэврийн даатгал	62,865,588.31	62,938,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,220,408.00	7,404,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,453,841.84	5,864,896.90
210204	Ажилгүйдлийн даатгал	1,241,494.83	1,405,508.82
210205	Эрүүл мэндийн даатгал	12,414,947.60	14,544,500.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,250,200.00	19,786,813.50
210301	Гэрэл, цахилгаан	5,369,700.00	5,341,880.00
210302	Түлш, халаалт	10,800,000.00	12,887,833.50
210303	Цэвэр, бохир ус	2,080,500.00	1,557,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,376,637.00	12,748,422.50
210401	Бичиг хэрэг	667,600.00	244,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,687,252.00	9,265,722.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,935,285.00	2,642,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,086,500.00	595,800.00
2105	Нормативт зардал	00.00	287,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	287,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,018,212.50	1,831,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	238,200.00	196,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	92,700.00	77,900.00

210604	Урсгал засвар	1,687,312.50	1,556,600.00
2107	Томилолт, зочны зардал	992,000.00	2,359,800.00
210702	Дотоод албан томилолт	992,000.00	2,359,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,211,108.00	5,453,540.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,101,700.00	3,602,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	663,300.00	483,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,800.00	217,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,500.00	44,500.00
210807	Газрын төлбөр	183,808.00	241,340.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,059,578.18	96,301,730.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,174,289.25	8,330,262.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	302,300.00	1,223,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,582,988.93	86,747,868.22
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,552,115.83</b>	<b>9,524,529.41</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,941,800.00</b>	<b>00.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,941,800.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,610,315.83	9,524,529.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,610,315.83	9,524,529.41
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>26,753,651.81</b>	<b>19,693,903.03</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>26,753,651.81</b>	<b>19,693,903.03</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>840,973,618.50</b>	<b>887,515,436.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>100,000.00</b>	<b>100,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>100,000.00</b>	<b>100,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.00	100,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	100,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>840,873,618.50</b>	<b>887,415,436.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	823,662,000.00	861,986,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	823,662,000.00	861,986,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,211,618.50	25,428,536.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,524,600.00	18,498,650.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,089,706.00	6,679,886.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	597,312.50	250,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>831,000,164.50</b>	<b>879,661,436.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>831,000,164.50</b>	<b>879,661,436.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>805,448,048.67</b>	<b>870,136,906.59</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	680,759,610.59	731,338,323.96
210101	Үндсэн цалин	460,812,315.82	522,287,115.04
210102	Нэмэгдэл	196,090,465.63	161,226,592.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,856,829.14	31,940,367.35
210104	Урамшуулал	00.00	15,884,249.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,196,280.58	92,158,106.63
210201	Тэтгэврийн даатгал	62,865,588.31	62,938,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,220,408.00	7,404,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,453,841.84	5,864,896.90
210204	Ажилгүйдлийн даатгал	1,241,494.83	1,405,508.82
210205	Эрүүл мэндийн даатгал	12,414,947.60	14,544,500.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,250,200.00	19,786,813.50
210301	Гэрэл, цахилгаан	5,369,700.00	5,341,880.00
210302	Түлш, халаалт	10,800,000.00	12,887,833.50
210303	Цэвэр, бохир ус	2,080,500.00	1,557,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,376,637.00	12,748,422.50
210401	Бичиг хэрэг	667,600.00	244,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,687,252.00	9,265,722.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,935,285.00	2,642,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,086,500.00	595,800.00
2105	Нормативт зардал	341,700.00	287,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	341,700.00	287,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,018,212.50	4,781,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	238,200.00	196,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	92,700.00	777,900.00
210604	Урсгал засвар	1,687,312.50	3,806,600.00
2107	Томилолт, зочны зардал	992,000.00	2,359,800.00
210702	Дотоод албан томилолт	992,000.00	2,359,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,211,108.00	5,453,540.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,101,700.00	3,602,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	663,300.00	483,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,800.00	217,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,500.00	44,500.00
210807	Газрын төлбөр	183,808.00	241,340.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	302,300.00	1,223,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	302,300.00	1,223,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,552,115.83	9,524,529.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,941,800.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,941,800.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,610,315.83	9,524,529.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,610,315.83	9,524,529.41
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>9,973,454.00</b>	<b>7,854,000.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>9,973,454.00</b>	<b>7,854,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,973,454.00</b>	<b>7,854,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>9,973,454.00</b>	<b>7,854,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,973,454.00	7,854,000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-9,973,454.00</b>	<b>-7,854,000.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,273,463.60	43,895,785.58	(231,088,068.69)	-	440,081,180.49
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,273,463.60	43,895,785.58	(231,088,068.69)	-	440,081,180.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	627,273,463.60	43,895,785.58	(231,088,068.69)	-	440,081,180.49
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	19,693,903.03	-	19,693,903.03
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,273,463.60	43,895,785.58	(211,394,165.66)	-	459,775,083.52

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>862,086,900.00</b>	<b>852,562,370.59</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>862,086,900.00</b>	<b>852,562,370.59</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>862,086,900.00</b>	<b>852,562,370.59</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	740,455,500.00	731,338,323.96
210101	Үндсэн цалин	530,865,300.00	522,287,115.04
210102	Нэмэгдэл	161,636,000.00	161,226,592.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,954,200.00	31,940,367.35
210104	Урамшуулал	16,000,000.00	15,884,249.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,556,800.00	92,158,106.63
210201	Тэтгэврийн даатгал	62,938,700.00	62,938,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,404,500.00	7,404,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,923,600.00	5,864,896.90
210204	Ажилгүйдлийн даатгал	1,480,900.00	1,405,508.82
210205	Эрүүл мэндийн даатгал	14,809,100.00	14,544,500.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,805,300.00	15,805,300.00
210301	Гэрэл, цахилгаан	4,784,500.00	4,784,500.00
210302	Түлш, халаалт	9,750,700.00	9,750,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,270,100.00	1,270,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,210,600.00	5,210,600.00
210401	Бичиг хэрэг	244,800.00	244,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,687,900.00	2,687,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,682,100.00	1,682,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	595,800.00	595,800.00
2105	Нормативт зардал	287,200.00	287,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	287,200.00	287,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,535,100.00	1,535,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	196,600.00	196,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	77,900.00	77,900.00
210604	Урсгал засвар	1,260,600.00	1,260,600.00
2107	Томилолт, зочны зардал	523,800.00	523,800.00
210702	Дотоод албан томилолт	523,800.00	523,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,462,200.00	5,453,540.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,602,200.00	3,602,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	483,700.00	483,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,800.00	217,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,500.00	44,500.00
210807	Газрын төлбөр	250,000.00	241,340.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	250,400.00	250,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,400.00	250,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>862,236,900.00</b>	<b>852,562,370.59</b>

1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>861,986,900.00</b>	<b>852,462,370.59</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	861,986,900.00	852,462,370.59
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>100,000.00</b>	<b>100,000.00</b>
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	100,000.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>58</b>	<b>58</b>
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	56	56
620003	Үйлчлэх ажилтан	1	1

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>25,428,536.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>25,428,536.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		25,428,536.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		3,981,513.50
210301	Гэрэл, цахилгаан		557,380.00
210302	Түлш, халаалт		3,137,133.50
210303	Цэвэр, бохир ус		287,000.00
210304	Байрны түрээс		00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		7,537,822.50
210402	Тээвэр, шатахуун		6,577,822.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		960,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		11,100,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		4,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		700,000.00
210604	Урсгал засвар		6,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		1,836,000.00
210702	Дотоод албан томилолт		1,836,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	973200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		973,200.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	25428536.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		25,428,536.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		18,498,650.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,679,886.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		250,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь Аймаг, хотын нутаг дэвсгэрт ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний улсын сүлжээний хэвийн ажиллагаа, нэгжүүдийн зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, ус цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээг зохион байгуулж, төлөв байдлыг үнэлэх, төр, аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдийг мэдээллээр хангах үйл ажиллагаа эрхлэн явуулдаг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын эрх зүйн орчныг боловсронгуй болгон, үйл ажиллагааг цахимжуулж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-ын удирдамжийн дагуу холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388, 32-дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох

бүртгэлийн дансны заавар” “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”, “Сангийн сайдын 2008 оны Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 252 дугаар тушаалыг баримтлал болгон бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99,702.8 мянган төгрөгөөр буюу 32.9 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	38,351.1	45,110.2	6,759.1
Үндсэн хөрөнгө	401,730.1	414,664.9	12,934.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>440,081.2</b>	<b>459,775.1</b>	<b>19,693.9</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	440,081.2	459,775.1	19,693.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>440,081.2</b>	<b>459,775.1</b>	<b>19,693.9</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 45,110.2 мянган төгрөг болж, 6,759.1 мянган төгрөгийн нэмэгдсэн байна. ЦУОШГазрын төвлөрсөн агуулахаас 11,230.6 мянган төгрөгийн материал хүлээн авсан нь нөлөөлсөн. Аж ахуй, бичиг хэрэг, түлш шатахуун гэх мэт 27,815.7 мянган төгрөгийн бараа, материал төсвийн хөрөнгөөр худалдан авч 32,286.9 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 414,664.9 мянган төгрөг болж, 12,934.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БОАЖ-ын сайдын А/31 тоот тушаалаар 17,500.0 төгрөгийн их засвар хийж, дээврийг сольсон байна. Төсвийн хөрөнгөөр тоосжилтын судалгаанд шаардлагатай 7,854.0 мянган төгрөгийн зургийн аппарат, иридум гар утас гэх мэт хөрөнгө худалдан авсан ба ЦУОШГазраас хуваарилагдан ирсэн цаг агаарт зориудаар нөлөөлөхөд шаардлагатай 74,328.7 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг орлогод бүртгэсэн, 12,900.1 мянган төгрөгийн компьютер, эд хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 52,852.6 мянган төгрөг буюу 5.6 хувиар өссөн байна. Энэ нь хандив, тусламжаар авсан 27.6 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр хүлээн авсан орлогуудтай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 59,912.4 мянган төгрөг буюу 6.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нэмэгдэл, унаа хоолны хөнгөлөлт болон урамшуулалтай холбоотой зардал байна. Цалингийн зардал 60.0 сая төгрөгөөр өссөн боловч нэмэгдэл цалин 34.9 сая төгрөгөөр буурч, унаа хоолны нэмэгдэл 8.1 сая, урамшууллын зардал 15.9 сая, нийгмийн даатгалын зардал 3.9 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 962,504.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид

хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 100,417.4 мянган төгрөгөөр бууруулж, 862,086.9 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 862,086.9 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 887,415.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан ба дээд шатны байгууллагаас 103,968,0 мянган төгрөгийн бараа материал, хөрөнгө авч, урсгал үйл ажиллагаанд 971,789.6 мянган төгрөг зарцуулж 19,693.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 971,789.6 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон унаа хоол бусад нөхөн олговрын зардал 9,117.2 мянга, АО-оос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 398.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 0.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

#### **Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	912,643,9	971,689.6	9,524.5	98.9%
2	Туслах үйл ажиллагаа	100.0	100.0	-	100%
НИЙТ		912,743.0	971,789.6	-	98.9%

Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 98.9 хувьтай хэрэгжсэн нь 2 ажилтан хүүхэд асрах чөлөө авч, түр хавсран ажиллуулсантай холбоотой цалин, нэмэгдэл урамшууллын зардал 9,524.5 мянган төгрөгөөр хэмнэгдэж дээд шатны төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЗДНХ, түүнтэй адилтгах хөрөнгөөс 18,498.7 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 6,679.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Уг санхүүжилтээр орон нутгийн тоосжилтын судалгаанд шаардлагатай болон цаг агаарт зориудаар нөлөөлөхөд шаардлагатай 11,100.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг худалдан авсан. Мөн тээвэр, шатахуун, халаалт гэрэл цахилгааны гэх мэт урсгал зардалд 11,519.3 мянган төгрөг, томилолтын зардалд 1,836.0 мянган төгрөг, шинэ ажилтаны сургалтын зардалд 973.2 мянган төгрөг зарцуулсан байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.4 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн МНБ,ТМЗ, аудитор Б.Бүзмаа, аудиторын туслах Т.Цагаанбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер С.Энхтөр Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны 130/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.5 хувиар буюу 13,678.2 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9,574.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>, 15.2.3<sup>2</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд 287.2-3,578.5 мянган төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 490.7 мянган төгрөг, бичиг хэргийн зардал 422,8 мянган төгрөгөөр хэмнэсэн боловч тээвэр, шатахууны зардал 3,578.5 мянга, халаалтын зардал 2,087.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

---

<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Тээвэр шатахууны зардал: Шатах тослох материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.
- Халаалтын зардал: Түлш шатахууны үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор нүүрс хэрзэн бэлтгэх тээврийн зардал өссөн нь нөлөөлөл үзүүлсэн байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроож, мэдээлсэн. Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш төгрөгийн шууд захиран зарцуулалт байхгүй байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн залруулга, албан шаардлагыг 100% бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт  
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Залруулга	2	10,788.7	2	10,788.7	100%
Албан шаардлага	1	9,973.5	1	9,973.5	100%
Төлбөрийн акт	1	3,036.7	1	3,036.7	100%
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>23,788.9</b>	<b>4</b>	<b>23,788.9</b>	<b>100.0%</b>

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 6,802.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,783.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 539.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, байгууллагын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр 2.940.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг хүргүүллээ.

### **5.1 Төлбөрийн акт**

Нэр бүхий 2 ажилтанд “олговоргүй сул зогсолт”-ын төрлөөр ажил олгогчоос НДШ-д 338.1 мянган төгрөг илүү төлсөн байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 41 дүгээр зүйлийн 41.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, “үнэн зөв байх” “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Олговол зохих цалингаас 112.4 мянган төгрөг дутуу, 88.6 мянган төгрөгийг илүү суутгаж цалин олгосон. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 41 дүгээр зүйлийн 41.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 539.1 төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

### **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Цалингийн зардалд Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмжийг оруулж тооцсон боловч ХХОАТ, Нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй бүртгэл хөтөлсөн.

##### Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар мөрдөж байгууллагын НБББББ стандартын дагуу бүртгэлд тусгах.

##### Илрүүлэлт:

Бэлтгэн нийлүүлэгчдэд мөнгө төлж худалдан авалт татварын цахим төлбөрийн баримтын системд буруу бүртгэсэн.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 5 дугаар 20 дугаар НӨАТ-ын тухай хуулийн 17-р зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар мөрдөж байгууллагын НБББББ стандартын дагуу бүртгэлд тусгах.

#### **4. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 3 мэдээ хугацаандаа байршуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбоотой мэдээ мэдээлийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т заасан хугацаанд мэдээлэх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Хувь хүнээс худалдан авсан зарлагын гүйлгээг И цахим төлбөрийн баримтын системд борлуулалт болгон шивсэн.	4	2,480.0	-	-	4	2,480.0	4	2,480.0	-	-		
Цалингийн зардлаас илүү дүнгээр НДШ-ийн тайланг тайлагнаж баталгаажуулсан	2	2940.0			2	2,940.0			2	2,940.0		
ХХОАТ-ын тайлан Цалингийн зардлын тайлангаас зөрүүтэй тайлагнасан	8	842.9			5	842.9	5	842.9				
Худалдан авалт хийсэн нийт 37 бэлтгэн нийлүүлэгчээс илүү дүнгээр цахим баримт шивэгдсэн.												
Цалингийн зардлаас НДШ илүү тооцож төлсөн.	2	338.1			2	338.1			2	338.1		
Цалингаас НДШ дутуу суутган цалинг илүү олгосон	5	112.4			5	112.4			5	112.4		
Цалингаас НДШ илүү суутган цалинг дутуу олгосон	3	88.6			3	88.6			3	88.6		
<b>Нийт дүн</b>	<b>24</b>	<b>6,802.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>24</b>	<b>6,802.0</b>	<b>9</b>	<b>3,322.9</b>	<b>2</b>	<b>3,479.1</b>		

